



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ

2025 оны 09 сарын 18 өдөр

Дугаар 1/13

Цэнхэрмандал сум

Өмч хамгаалах Байнгын зөвлөл
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1 дэхь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 77 дугаар зүйлийн 77.2.1 дэх заалт, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1.1, 2.1.2 дах заалт, 8 дугаар бүлгийн 8.2 дах заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын Өмч хамгаалах Байнгын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга:	Арга зүйч
Нарийн бичиг:	Нягтлан бодогч
Гишүүн:	Хөгжмийн багш

2. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулан биелэлтийг хагас, бүтэн жилээр Цэцэрлэгийн эрхлэгчид танилцуулж ажиллахыг Өмч хамгаалах Байнгын зөвлөлийн дарга /Э.Сугармаа/-д даалгасугай.

3. Өмч хамгаалах Байнгын зөвлөл нь хууль, журмын хүрээнд ажиллах ба ажлын үр дүнг харгалзан холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн нэмэгдэл цалин хөлс, урамшуулал олгохыг нягтлан бодогч Д.Ганчимэгт зөвшөөрсүгэй.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 11 сарын 28-ны өдрийн А/15 дугаар тушаал хүчингүй болсонд тооцсугай.

ЭРХЛЭГЧ



П.ГАНТУЯА